

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА (ОУИТБС)

Монгол улсын баталгаажуулалт

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээ

2018 оны 1 дүгээр сарын 18

Агуулга

1. Тойм.....	2
2. Үндэслэл.....	2
3. Засан залруулах арга хэмжээнд хийсэн Нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээ.....	4
3.1 Засан залруулах арга хэмжээ 1.....	4
3.2 Засан залруулах арга хэмжээ 2.....	6
3.3 Засан залруулах арга хэмжээ 3.....	9
3.4 Засан залруулах арга хэмжээ 4.....	11
3.5 Засан залруулах арга хэмжээ 5.....	12
3.6 Засан залруулах арга хэмжээ 6.....	15
3.7 Засан залруулах арга хэмжээ 7.....	17
3.8 Засан залруулах арга хэмжээ 8.....	18
4. Дүгнэлт.....	20

1. Тойм

Монгол улс дахь ОУИТБС-ын хоёр дахь удаагийн баталгаажуулалт нь 2018 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс хийгдэж эхэлсэн юм. Монгол улсад 2016 онд хийгдсэн анхдугаар баталгаажуулалтын үр дүнд үндэслэн ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооны зүгээс Монгол улсад хандан тогтоосон засан залруулах найман арга хэмжээний хүрээнд гарсан ахиц дэвшилд ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар үнэлгээ хийж гүйцэтгээд байна¹. Эдгээр засан залруулах найман арга хэмжээ нь:

1. ОТОБ-ын хяналт (шаардлага 1.4.b.vi & 1.4.b.iii);
2. Тусгай зөвшөөрөл олголт (шаардлага 2.2) тусгай зөвшөөрлийн бүртгэлийг (шаардлага 2.3) ил тод болгох
3. Төрийн оролцоо (шаардлага 2.6) болон төсвийн шинжтэй зарцуулалт (шаардлага 6.2);
4. Төрийн өмчит компаниудтай холбоотой шилжүүлэг (шаардлага 4.5);
5. Мэдээллийн чанар, баталгаажуулалт (шаардлага 4.5);
6. Орон нутгийн шилжүүлэг (шаардлага 5.2);
7. Олборлох үйлдвэрлэлийн компаниудын нийгмийн чиглэлтэй зарцуулалт (шаардлага 6.1); болон,
8. ОУИТБС-ын хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөний үнэлгээ (шаардлага 7.4).

Нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс Монгол улс нь дээр дурдсан бүхий л засан залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж, хамаарах шаардлагад нийцэхийн тулд “хангалттай хэмжээнд ахиц дэвшил” гаргасан хэмээн үнэлж байна. Үнэлгээний тайлангийн төслийг 2018 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр ОТОБ-т илгээсэн бөгөөд [ОГНОО ОРУУЛАХ] өдөр ирүүлсэн саналын дагуу үнэлгээний дүнг эцэслэн нэгтгэж, Удирдах хороонд танилцуулах болно.

¹ <https://eiti.org/validation/mongolia/2016>

2. Үндэслэл

Монгол улс нь ОУИТБС-ын нэр дэвшигч улсаар анхлан 2007 оны 9 дүгээр сард хүлээн зөвшөөрөгдөж, улмаар 2010 оны 10 дугаар сард ОУИТБС-ын Журмын дагуу хэрэгжүүлэгч орны статустай болсон юм. Монгол улс ОУИТБС-ын Стандартуудыг хангаж буй эсэхийг баталгаажуулах үйл явц 2016 оны 7 дугаар сард анх хийгдэж эхэлсэн юм. Улмаар ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооны зүгээс 2016 онд батлагдсан ОУИТБС-ын стандартыг хангах чиглэлээр Монгол улс нь тодорхой хэмжээний ахиц дэвшил гаргасан хэмээн дүгнэжээ. Удирдах хороо нь дараах шаардлагуудад хамаарах засан залруулах найман үйл ажиллагааг тодорхойлон гаргасан ба эдгээрт: ОТОБ-ын засаглал (1.4), тусгай зөвшөөрөл олголт (2.2) тусгай зөвшөөрлийн бүртгэл (2.3), төрийн оролцоо (2.6), үүнд ТӨК-иудын шилжүүлэг (4.5) болон төсвийн шинжтэй зарцуулалт (6.2), мэдээллийн чанар (4.9), орон нутгийн шилжүүлэг (5.2), олборлох үйлдвэрлэлийн компаниудын нийгмийн чиглэлтэй зарцуулалт (6.1) болон ОУИТБС-ын хэрэгжилтийн үр нөлөөг баримтжуулах (7.4) зэрэг арга хэмжээ багтаж байв. Удирдах хорооны зүгээс Монгол улсад хандан 2018 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр эхлэх ёстой хоёрдахь баталгаажуулалтаар үнэлгээ хийгдэх эдгээр засан залруулах арга хэмжээг хүсэлтийг гаргасан билээ.

Эдгээр засан залруулах арга хэмжээний хүрээнд Монгол улс нь хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэний тоонд дараах үйл ажиллагаа багтаж байна:

- 2017 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар ОТОБ нь Монгол улсын 2016 оны баталгаажуулалтад хамаарах засан залруулах арга хэмжээнд хамаарах Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан гаргасан.
- 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр ОТОБ нь ОУИТБС-ын 2016 оны тайлангийн цар хүрээг боловсруулан гаргаж, энэ талаар тухайн тайланд нэгтгэн тулгалт хийх Хараат бус нэгтгэгч болох KPMG (Монгол, Франц) компанитай тохиролцсон.
- 2017 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр ОТОБ-ийн зүгээс 2016 оны баталгаажуулалтаар заагдсан засан залруулах арга хэмжээнд гарч буй ахиц дэвшлийг үнэлэх нэг өдрийн семинар зохион байгуулж, хүлээгдэж буй үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн гаргажээ.
- ОТОБ нь 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаар 1.4 дүгээр шаардлагад хамаарах өөрийн үйл ажиллагааны дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.
- 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 2016 оны Монголын ОУИТБС-ын тайлан, 2017 оны жилийн тайлан болон 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэвлэн нийтэлжээ.
- 2018 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр ТАН эвсэл болон олборлох үйлдвэрийн компаниудын төлөөлөл Монголын ОУИТБС-ын вебсайт дээр өөрийн төлөөллийг нэр дэвшүүлэх, томилон ажиллуулах журмуудаа нийтэлсэн байна.

Дараах хэсэг дээр засан залруулах арга хэмжээ нэг бүрээр авч хэрэгжүүсэн үйл ажиллагаа, ахиц дэвшлийг заасан. Тухайн үнэлгээ нь Удирдах хорооны зүгээс даалгасан үйл ажиллагаа болон ОУИТБС-ын стандартад заагдсан хамаарах шаардлагуудаар хязгаарлагдсан болно. Үнэлгээ нь Баталгаажуулалтын зааварчилгааг баримтлан хийгдсэн². Энэхүү үнэлгээг хийж гүйцэтгэхдээ Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар нь нэмэлт шаардлагуудын биелэлтийг судлан үзэх шаардлага буй эсэхийг мөн харгалзсан бөгөөд жишээ нь 2016 оны Баталгаажуулалтаар “хангалтай” эсвэл “өндөр” хэмжээний ахиц бүхий хэмээн үнэлэгдсэн шаардлагуудыг мөн харгалзан үзсэн. Хэдийгээр тухайн шаардлагуудын иж бүрэн хэмжээнд үнэлээгүй ч Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс тухайн чиглэлд гарсан ахиц дэвшил эргэн буурч стандартад үл нийцэх түвшинд

² https://eiti.org/sites/default/files/documents/validation-guide_0.pdf

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээний төсөл

хүрсэн, ОУИТБС-ын Удирдах хорооны зүгээс хянан үзэх шаардлагатай нэмэлт асуудлууд үүдэн гарсан байж болох нотолгоог олоогүй болно.

3. Засан залруулах арга хэмжээний тойм

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс хийсэн үнэлгээ нь тухайн санал болгосон засан залруулах арга хэмжээг хангалттай хэмжээнд авч хэрэгжүүлсэн эсэхийг үнэлэн дүгнэсэн. Үнэлгээг 2017 оны 1-12 дугаар сарын хооронд хуралдсан ОТОБ-ын хурлын тэмдэглэл, 2015 болон 2016 оны ОУИТБС-ын тайлан, 2017 оны жилийн ажлын явцын тайлан, 2018 оны ажлын төлөвлөгөө болон ОТОБ-ийн зүгээс Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлсэн бусад баримт бичгүүд, цахим шуудангаар хийгдсэн захидал харилцаа болон оролцогч талуудтай хийсэн яриа хэлэлцүүлэг (биечлэн болон Скайп) зэрэг дээр үндэслэн хийсэн болно.

3.1 Засан залруулах арга хэмжээ 1

Шардлага 1.4.b.vi дээр заасныг баримтлан ОТОБ нь санаачилгын хэрэгжилтийн бүхий л явцад оролцогч бүх талыг түншлэгч хэмээн ижил хандаж оролцоот шийдвэр гаргаж байхыг баталгаажуулах үүрэг хүлээнэ. ОТОБ нь олон талт бүлэгт ажиллах бүлэг бүр нь өөрийн төлөөллийг нэр дэвшүүлэх болон солих журмыг хэлэлцэн баталж, хэвлэн нийтэлсэн байна. Шаардлага 1.4.b.iii дээр заасны дагуу ОТОБ-ын гишүүд нь өөрийн хамаарах, төлөөлж буй бүлэгтэй хамтран ажиллаж байх үүргийг хүлээнэ.

Анхны баталгаажуулалтын үр дүн

Анхдугаар баталгаажуулалтаар Монгол улс нь энэхүү шаардлагын биелэлтийг хангах чиглэлд тодорхой ахиц дэвшил гаргасан хэмээн дүгнэжээ. ОТОБ байгуулагдаж, тус бүлэгт хамаарах оролцогч тал нэг бүрийн төлөөлөгчид нь хөндлөнгийн ямар нэгэн санал, нөлөөлөл, албадлагагүйгээр томилогдон ажиллаж байна. Харин баталгаажуулалтын үнэлгээнд дурдсанаар ОТОБ-ын журам (Гүйцэтгэх үүрэг, чиг үүргийг багтаасан) нь ОУИТБС-ын стандарт шаардлагуудыг хангахуйц буй ч оролцогч талуудын зүгээс бодит практик дээр, ялангуяа санал хураалт дээр тодорхой байдлаар зөрчигдөж буйг дурдсан байдаг. Оролцогч талуудын аль нэг бүлэг татгалзсан санал өгсөн ч ОТОБ-ын тодорхой шийдвэрүүд, жишээ нь мэдээллийн чанарын баталгаажилттай холбоотой шийдвэр батлагдаж байжээ. ОТОБ-ийн гишүүдийн оролцоо, ирц хангалтгүйн зэрэгцээ томилогдон ажиллаж буй этгээдүүд биечлэн бус харин төлөөлөө илгээн оролцуулах нь түгээмэл байна. Баталгаажуулалтаар олон нийтэд нээлттэйгээр батлан гаргасан ОТОБ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх журамд өөрийн төлөөлж буй бүлэгтэй үйл ажиллагаагаа зохицуулах талаарх авч буй арга хэмжээний нотолгоо хангалтгүй буй нь ОТОБ дээрх хэлэлцүүлэг дээр талуудын төлөөллийн нөхцөл байдлыг сулруулж байна хэмээн үзжээ. Баталгаажуулалтаар эдгээр дээр дурдсан сул талууд нь ОУИТБС-ын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, ОУИТБС-ын тайлангийн техникийн тал дээр, ялангуяа мэдээллийн чанарын асуудлаар олон талын оролцоот хяналт зохистой бүс хэмжээнд хийгдэхэд хүргэж байна хэмээн тооцжээ.

Баталгаажуулалтаас хойш гарсан ахиц дэвшил

ОУИТБС-ын ОТОБ болон Үндэсний зөвлөл нь Монгол улсад хийгдсэн анхдугаар баталгаажуулалтын хүрээнд тогтоосон ОУИТБС-ын хэрэгжилтэд оролцогч талуудын үр дүнтэй хяналт дутагдаж буй асуудлыг шийдэх зорилгоор хэд хэдэн алхам хийгээд байна. 2017 оны 11 дүгээр сарын 15-нд болсон хуралдаанаар ОТОБ нь өөрийн үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулан талуудын үүрэг

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээний төсөл

роль, чиг үүргийг тодорхой болгосноос гадна дотоод засаглалын журамдаа мөн өөрчлөлт оруулжээ.³ ОУИТБС-ын ОТОБ-ийг бүрдүүлж буй талууд нь ОТОБ болон Үндэсний зөвлөлд өөрийн төлөөллийг нэр дэвшүүлэх, томилох журмуудыг батлан гаргаад байна. Нэмэлт өөрчлөлт хийгдсэн (2017 оны 11 дүгээр сард) ОТОБ-ын журам, чиг үүрэг нь төрийн байгууллагуудын төлөөллийг нэр дэвшүүлэх журмыг багтааж, ОТОБ-т төрийн байгууллагуудын төлөөллийг нэр дэвшүүлэх болон өөрчлөх Ерөнхий сайдын үүрэг хариуцлагыг баталгаажуулжээ (8.1 дүгээр зүйл). Бусад талуудын зүгээс ОТОБ-т ажиллах гишүүнийг нэр дэвшүүлэх журмыг (олборлох үйлдвэрлэлийн салбар болон иргэний нийгэм) 2018 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр Монголын ОУИТБС-ын вебсайт дээр нийтэлжээ.⁴ Монгол улсын анхдугаар баталгаажуулалттай холбоотой Удирдах зөвлөлийн шийдвэр 2018 оны 1 дүгээр сард гарсанаас хойш ОТОБ-т төлөөлөл бүхий аль ч тал нь ОУИТБС дахь өөрийн төлөөллийн зэрэглэл, түвшинтэй хамааралтай сэтгэл зовнихуйц асуудлыг илэрхийлэн гаргаагүй байна.

ОТОБ-ын журамд 2017 оны 11 дүгээр сард хийгдсэн өөрчлөлт нь ОТОБ-ын гишүүдийн үүрэг роль, хариуцах ажил зэргийг илүү дэлгэрүүлсэн ба үүнд ОТОБ-ын хуралдаан, хэлэлцүүлэг болон шийдвэр гаргалтад оролцож байх үүргийг тодорхойлон гаргажээ (15 дугаар зүйл). Журамд оруулсан өөрчлөлтөөр мөн ОТОБ-ын хурлын ирц, хуралдаан хүчин төгөлдөр болохтой оролцоотой холбоотой өөрчлөлт оруулсан байна. Практик дээр үзвэл 2017 онд зохион байгуулагдсан 3 удаагийн хурлын ирц сайжирсан бөгөөд, 2012 оны 11 дүгээр сарын журмын дагуу ирц эхний хоёр хурлаар, нэмэлт өөрчлөлт оруулсан журамд заасан ирц 2017 оны 11 дүгээр сарын хурлаар бүрэн бүрджээ (Монголын ОУИТБС-ын вебсайт дээрх ОТОБ-ын хуралдааны ирцийг үзнэ үү⁵).

ОТОБ-ын журамд хийгдсэн 2017 оны 11 дүгээр сарын өөрчлөлтөөр ОТОБ дээр шийдвэр гаргахтай холбоотой журмыг мөн өөрчлөн сайжруулжээ. Энэхүү журмаар оролцогч тал нэг бүрийг тэгш хэмээн үзэж, ОТОБ дээр шийдвэр гаргахдаа зөвшилцлийн зарчмыг баримтлахыг шууд дурдсан байна. Журамд зааснаар шийдвэр гаргах үйл явцад “ойлголцол бий болохгүй” бол түр ажлын хэсэг байгуулан зөвлөлдөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх (41 дүгээр зүйл), улмаар санал хураалт явуулан нийт оролцогчдын 3/2-ын саналаар шийдэхээр (42 дүгээр зүйл) заажээ. Шинэчилсэн журам нь ОТОБ-ын гишүүд гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй болохыг шууд заасан байна (45 дугаар зүйл).

Практик дээр ОТОБ нь ОУИТБС-ын тайлангийн техникийн тал дээр өөрийн хяналтын шат дараатай нэмэгдүүлж бэхжүүлж буй нь 2016 оны тайлан сайжирсан, Монгол улсын Ерөнхий аудитортой (ҮАГ) Засгийн газрын зүгээс бэлтгэн гаргасан ОУИТБС-ын тайланг баталгаажуулж байх гэрээ байгуулсан зэргээс илт харагдаж буй бөгөөд энэ нь ОТОБ нь ОУИТБС-ын тайлагнах үйл явцад өөрийн хяналтыг нэмэгдүүлж буйн тусгал болж байна. Түүнчлэн 2016 оны ОУИТБС-ын тайлангийн цар хүрээтэй холбоотойгоор оролцогч талуудын хооронд зөвлөлдөх, зохицуулалтын арга хэмжээ явагдаж, үүнд тусгай зөвшөөрөл олголтыг оруулах, судлан үзэх шаардлагатай шилжүүлгүүдийг сонгох, чанарын баталгаажилтын журам зэрэг дээр өөрчлөлт хийгдсэн байх нотолгоо харагдаж байна.

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээ

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс оролцогч талуудын хяналтын асуудлыг Монголын ОУИТБС анхааралдаа авсанд сэтгэл хангалуун буй бөгөөд 1.4 дүгээр шаардлагын хүрээнд Монгол улс нь хангалттай хэмжээнд амжилт гаргасан хэмээн үзэж байна. Оролцогч тал нэг бүр

³ Монголын ОУИТБС (2017 оны 11 сар), ‘ОУИТБС-ын үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ОТОБ-ын ажиллах журам’, 2018 оны 1 сарын байдлаар [энд](#) үзнэ үү.

⁴ Монголын ОУИТБС (2018 оны 1 сар) ‘ОТОБ-ийн гишүүдэл төлөөлөл томилох журам’, 2018 оны 1 сарын байдлаар [энд](#) үзнэ үү.

⁵ Монголын ОУИТБС (2017 оны 12 сар), ‘ОТОБ-ийн хурлуудын ирц, 2014-2017’, 2018 оны 1 сарын байдлаар [энд](#) үзнэ үү.

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээний төсөл

өөрийн төлөөллийг ОТОБ-т нэр дэвшүүлэх журмыг олон нийтэд нээлттэйгээр боловсруулан, 2018 оны 1 дүгээр сард ил тод түгээжээ. ОТОБ дээрх шийдвэр гаргалтад хамрагдах баталгаа дутмаг байсан асуудлыг 2017 оны 11 дүгээр сард ОТОБ-ын журамд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэжээ. 2017 оны туршид ОТОБ-ын хуралдаанууд дахь гишүүдийн оролцоо сайжирсан, ОТОБ нь өөрийн шинэчлэн нэмэлт өөрчлөлт оруулсан журамд гишүүдийн ирцтэй холбоотой чанд журмыг оруулжээ. Түүнчлэн 2016 оны ОУИТБС-ыг бэлтгэн гаргахаас өмнө, үүний цар хүрээг тогтооход өөрийн төлөөлж буй талуудтай харилцан зохицуулалт хийх нь нэмэгдэж буй нотолгоо харагдаж байна.

3.2 Засан залруулах арга хэмжээ 2

Шаардлага 2.2.а дээр заасны дагуу Засгийн газар нь тухайн жилд ашигт малтмал, газрын тос болон байгалийн хийн салбарт олгосон болон шилжүүлсэн тусгай зөвшөөрлийг, тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэхтэй холбоотой эрх зүйн болон зохицуулалтын хэм хэмжээ зөрчигдсөн байдлын хамтаар ил тод болгох арга хэмжээг авна.

2.3 дугаар шаардлагын дагуу Засгийн газар нь ашигт малтмал, газрын тос болон байгалийн хийн тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан огноог олон нийтэд нээлттэй болгон, газрын тос болон байгалийн хийн тусгай зөвшөөрлийн талбайн солбилцлыг хэвлэн нийтэлнэ.

Анхны баталгаажуулалтын үр дүн

Анхдугаар баталгаажуулалтаар Монгол улс нь 2.2 дугаар шаардлагыг хангах чиглэлээр тодорхой хэмжээний ахиц дэвшил гаргаад байна хэмээн дүгнэжээ. Баталгаажуулалтад дурдсанаар ОУИТБС-ын 2014 оны тайланд тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэхтэй холбоотой хэрэгцээтэй зарим мэдээллийг тусгасан ч тухайн тайлант хугацаанд олгосон болон шилжүүлсэн нийт тусгай зөвшөөрлийн тоо тодорхойгүй хэвээр үлдсэнийг дурджээ. Баталгаажуулалтаар мөн ОУИТБС-ын тайлан нь тусгай зөвшөөрөл олгох журмаас гадуур ямар нэгэн үйл явц хийгдсэн эсэхийг ил тод болгон мэдээлээгүй байна.

Үүний зэрэгцээ 2.3 дугаар шаардлагыг ханган биелүүлэхэд Монгол улс тодорхой ахиц гаргасан хэмээн дүгнэлт гарсан юм. 2014 оны ОУИТБС-ын тайланд 2.3 дугаар шаардлагын ихэнх хэсгийг 2014 оны тайлан, АМГТГ-ын кадастрын мэдээллийн систем болон ОУИТБС-ын цахим тайлангийн системд оруулж, ил тод болгосон ч ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргасан огноо тодорхойгүй байна. Газрын тос, байгалийн хийн салбарын хувьд тусгай зөвшөөрөл хүсэмжилсэн өргөдөл гаргасан огноо, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн болон тусгай зөвшөөрлийн талбайн солбицол зэрэг мэдээлэл байхгүй.

Баталгаажуулалтаас хойш гарсан ахиц дэвшил

2.2 дугаар шаардлагатай холбоотой засан залруулах арга хэмжээний хувьд 2016 оны ОУИТБС-ын тайланд 2016 онд олгосон болон шилжүүлсэн тусгай зөвшөөрөлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл оруулж, хууль журмаар тогтоосон журам ноцтой зөрчигдсөн тохиолдол буй эсэхийг үнэлэн үзсэн байна.

Ашигт малтмалын салбарын хувьд ОУИТБС-ын 2016 оны тайланд тухайн жил олгосон болон шилжүүлсэн тусгай зөвшөөрлийн тоог дурдан баталгаажуулжээ. Тус тайланд дурдсанаар тухайн жил 716 тусгай зөвшөөрөл олгож (хайгуулын 623, ашиглалтын 93), 148 тусгай зөвшөөрөл (хайгуулын 52,

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээний төсөл

ашиглалтын 96) шилжүүлсэн байна (хуудас.87, 89⁶). Тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэхтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл, үүнд хүлээн авсан этгээдийн нэр зэрэг мэдээллийг Хавсралт 17.a-18.b (х/хуудас.74-83⁷) болон Хавсралт 19 (х/хуудас.87-89) дээр тус тус багтаажээ.

2016 олгосон болон шилжүүлсэн тусгай зөвшөөрлийн хэвийн бус хөдөлгөөний хувьд Хараат бус нэгтгэгч нь эрсдэлд суурилсан хандлага/аргачлал ашиглахаар ОТОБ-тэй тохиролцсон байна. Хараат бус нэгтгэгч нь тусгай зөвшөөрөл олголт, шилжүүлэлттэй холбоотой дагалдах баримт бичгүүдийг үзэж, нийт 52 тохиолдлыг (нийт 864 тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэхтэй холбоотой, нийт 6%-тэй тэнцэх) шалгаж үзжээ. ОТОБ-ийн зүгээс 6 тусгай зөвшөөрөл олголт⁸ болон шилжүүлсэн⁹ тохиолдлыг “эрсдэлтэй” хэмээн үзэж судлан үзэх хүсэлт гаргасан бол Хараат бус нэгтгэгч нь санамсаргүй түүврээр нэмэлт 44 тусгай зөвшөөрлийн (17 олголт, 17 шилжүүлэлт, 10 сонгон шалгаруулалтаар олгосон тусгай зөвшөөрөл) мэдээллийг шалгажээ (х.86). Тусгай зөвшөөрлийн хэвийн бус хөдөлгөөнд хийсэн үнэлгээний дэлгэрэнгүй үр дүнг Хавсралт 15 (х/хуудас.39-45) дээр оруулан, 11 тусгай зөвшөөрөл олголт, 6 шилжүүлэг дээрх мэдээллийн зөрүүтэй байдлыг дэлгэрэнгүй тусгажээ (хуудас.86). ОУИТБС-ын тайлан нь мөн Транспаренси Интернейшнл байгууллагын хийсэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл явц дахь авлигын эрсдлийг үнэлэх “Тогтвортой хөгжлийн төлөө уул уурхай” судалгааг¹⁰ үзэж болохыг мөн заажээ (хуудас.86).

Газрын тос, байгалийн хийн чиглэлээр тухайн тайлан нь 2016 онд өрсөлдөөнт шалгаруулалтын үндсэн газрын тосны бүтээгдэхүүн хуваах 2 гэрээ хийгдэж, нэг гэрээний хамаарах тал солигдсон болохыг тодруулан дурджээ (хуудас.95). Хуулиар тогтоосон журмын хэм хэмжээг зөрчсөн байдлын талаарх тайлбарыг 2016 онд шинээр хийсэн болон шилжүүлсэн Бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр гаргажээ (хуудас.95-96). Шинээр хийсэн Бүтээгдэхүүн хуваах хоёр гэрээний тендерт оролцож, ялалт байгуулаагүй талуудын жагсаалтыг мөн оруулжээ (хуудас.95). Хавсралт 21.c-d нь шинэ хоёр гэрээ, нэг шилжүүлсэн байдалтай хамаарах нэмэлт мэдээлэл багтаасан байна (х/хуудас.103-104).

2.3 дугаар шаардлагатай хамаатай заасан залруулах арга хэмжээний хувьд Монголын ОУИТБС-ын 2016 оны тайлан дээр уншигчдад зориулан тухайн шаардлага 2.3.b дээр заагдсан бүх идэвхтэй буй тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг хэрхэн авах талаар зааварчилгааг оруулжээ. ОУИТБС-ын тайлан болон АМГТГ-ын кадастрын мэдээллийг судлан үзсэний үндсэн дээр материаллаг босго давсан компаниудын эзэмшиж буй нийт 661 ашиглалтын тусгай зөвшөөрлөөс 251 тусгай зөвшөөрлийн, 11 Бүтээгдэхүүн хуваах гэрээний 8 гэрээний өргөдөл гаргасан огноог ил тод болгожээ (Хавсралт 20 (х/хуудас.90-93) болон 21.a (х/хуудас.94). Тухайн тайланд бүх тусгай зөвшөөрөл болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний өргөдөл гаргасан огноог ил тод болгоход тулгарч буй хүндрэлүүдийн талаар дэлгэрэнгүй, ил тодоор тайлбарлажээ. Тайланд дурдсанаар 2010 оноос өмнө түрүүлж ирсэнд-түрүүлж өгөх системийн дагуу тусгай зөвшөөрөл олгож байсан үед анхлан өргөдөл гаргасан огноог агуулсан цахим бүртгэл байхгүй, харин АМГТГ болон Хараат бус нэгтгэгч нь энэхүү мэдээллийг олж баталгаажуулах талаар нэмэлт ажиллагааг явуулжээ. Тайланд тооцсоноор өргөдөл гаргасан огноо нь ил тод болсон (хэвлэн нийтлэгдсэн) нийт 259 ширхэг ашигт малтмал, газрын тос болон байгалийн хийн тусгай зөвшөөрөл нь 2016 онд олборлох салбараас төвлөрүүлсэн нийт орлогын 98.8%-ийг

⁶ Хуудасны дугаар заасан нь Монголын ОУИТБС-ын баримт бичгийн хуудсаар тооцогдоно (2017 оны 12 сарын 31), ‘Монголын ОУИТБС-ын 2016 оны тайлан’, 2018 оны 1 сарын байдлаар [эндээс](#) үзнэ үү.

⁷ Хавсралт дээрх уудасны дугаар (х/хуудас) заасан нь Монголын ОУИТБС-ын баримт бичгийн хуудсаар тооцогдоно (2017 оны 12 сарын 31), ‘Монголын ОУИТБС-ын 2016 оны тайлангийн хавсралтууд’, 2018 оны 1 сарын байдлаар [эндээс](#) үзнэ үү.

⁸ XV-016319, XV-020580, XV-19691, XV-20704, MV-020875, MV-020877.

⁹ MV-009515, MV-020419.

¹⁰ Транспаренси Интернейшнл (2017 оны 6 сар), ‘Тогтвортой хөгжлийн төлөөх уул уурхай: Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоон дахь авлигын эрсдлийн үнэлгээ’, 2018 оны 1 сарын байдлаар [энд](#) байршсан.

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээний төсөл

бүрдүүлэгч компаниудад хамаарч байна (хуудас.91). ОУИТБС-ын 2018 оны ажлын төлөвлөгөө нь одоо хүчин төгөлдөр буй ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргасан огноог “цаг тухайд нь” ил тод болгох арга хэмжээг багтаажээ (Үйл ажиллагаа 1.1 болон 1.2).¹¹

Газрын тос, байгалийн хийн Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн солбилцлын хуьд Монголын ОУИТБС-ын мэдээллийн портал дээр эдгээр солбилцлүүдыг¹² ил тод болгон харуулсаны зэрэгцээ 2016 оны ОУИТБС-ын тайлангийн Хавсралт 21 дээр мөн оруулжээ (х/хуудас.95-102).

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээ

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэхтэй холбоотой ил тод байдлыг хангах засан залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж, 2.2 дугаар шаардлагыг хангах чиглэлд хангалттай хэмжээнд ахиц гаргасан хэмээн үзэж байна. Монголын ОУИТБС-ын 2016 оны тайлан нь тухайн жилд ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн ямар тусгай зөвшөөрөл олгосон болохыг дурдаж, тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэхтэй холбоотой эрх зүйн болон зохицуулалтын орчныг ямар хэм хэмжээ хэвийн бус байдлаар зөрчигдсэн болохыг тодруулжээ. Нарийн бичгийн дарга нарын газар нь практикаас гажсан зөрчилтэй үйлдлийг үнэлэх чиглэлээр ихээхэн ажил хийсэн нь тусгай зөвшөөрөл олгох үйл явцад шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн үнэлэх талаарх мэдлэг нэмэгдүүлсэн сайн жишээ болсон хэмээн үзэж байна. Практик дээр гарсан зөрчлийн талаар зөвлөмж хомс буй нь асуудал үүсгэх хэдий ч тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт болон шилжүүлэх үйл явцыг шалгахад ОТОБ оролцох боломжтой юм.

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс тусгай зөвшөөрлийн бүртгэлтэй хамаарах засан залруулах арга хэмжээнд Монгол улс анхаарал хандуулсанд сэтгэл хангалуун буй бөгөөд Монгол улс нь энэхүү шаардлага 2.3-ыг ханган биелүүлэх чиглэлээр хангалттай хэмжээнд ахиц дэвшил гаргасан хэмээн үзэж байна. Монголын ОУИТБСын 2016 оны тайланд газрын тос, байгалийн хийн тусгай зөвшөөрлийн талбайн солбилцлыг үнэлэх зааварчилгааг оруулсан байна. ОТОБ нь нийт 661 тусгай зөвшөөрлийн 251, 11 Бүтээгдэхүүн хуваах гэрээний 8-ынх нь өргөдөл гаргасан огноог ил тод болгож чадсан энэхүү ил болгоогүй буй өргөдлийн огноог ил тод болгох талаар хүчин чармайлт гаргаж, өмнө баримталж байсан тусгай зөвшөөрлийн системийн хүрээнд өргөдөл гаргаж байсан огноог ил тод болгоход тулгарч буй хүндрэл, бэрхшээлийн талаар илэн далангүй хандсан байна. ОТОБ нь өөрийн 2018 оны Ажлын төлөвлөгөөнд хүчин төгөлдөр ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн бүх тусгай зөвшөөрлийн өргөдлийн огноог ил тод болгох үйл ажиллагааг төлөвлөн оруулжээ. ОУИТБС-ын 2.3 дугаар шаардлага нь “Лицензийн бүртгэл, кадастрийн систем нь лиценз эзэмшиж буй бүх аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн талаарх мэдээллийг багтаасан байх бөгөөд үүнд ОУИТБС-ын тайланд хамрагдаагүй аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийг ч (тэдний төлж буй төлбөр нь босго хэмжээнд хүрээгүйн улмаас тайланд ороогүй байж болно) багтаан оруулна. Хэрэв ямар нэг эрх зүйн болон бусад шалтгааны улмаас хүчин төгөлдөр байгаа бүх лицензийн талаарх мэдээллийг ил тод болгох боломжгүй бол энэ талаархи тайлбарыг ОУИТБС-ын тайланд оруулна. Түүнчлэн, Засгийн газрын зүгээс энэхүү саад бэрхшээлийг арилгах талаар төлөвлөж буй ажлууд болон тухайн ажлыг хийж дуусах эцсийн хугацааг тодорхой дүрдсэн байх шаардлагатай” хэмээн заажээ. ОТОБ-ийн зүгээс тайлан гаргах компаниудыг сонгоход тавьсан босго дүн нь харьцангуй бага буй нь материаллаг босгоос дээш

¹¹ Монголын ОУИТБС (2018 оны 1 сар), ‘Монголын ОУИТБС-ын Ажлын төлөвлөгөө’, 2018 оны 1 сар, [энд](#) үзнэ үү.

¹² <http://www.eitimongolia.mn/mn/node/4922>

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээний төсөл хэмжээний төлбөр төлж буй компаниудын эзэмшиж буй олон тооны тусгай зөвшөөрлийг хамруулах боломж олгож байна.

3.3 Засан залруулах арга хэмжээ 3

Шаардлага 2.6 дээр заасанчлан ОТОБ нь ТӨК-иудын хуримтлагдсан ашиг болон дахин хөрөнгө оруулалттай холбоотой хэрэгжүүлж буй журам дүрмүүд, практикын талаар тайлбар гаргах ёстой. Засгийн газар нь мөн ТӨК болон тэдгээрийн охин компаниуд дахь төрийн өмчид тухайн жилд гарсан өөрчлөлтийг ил тод мэдээлэх, төр эсвэл ТӨК-ийн зүгээс үүл үүрхай, газрын тос, байгалийн хийн компаниудад олгосон зээл, зээлийн баталгааны талаарх иж бүрэн мэдээллийг гаргах үүргийг хүлээнэ.

6.2 дугаар шаардлагад заасны дагуу ОТОБ нь олборлох салбар дахь ТӨК болон тэдний охин компаниудын төсвийн шинжтэй зарцуулалт буй эсэх, (үүнд олгосон татаас мөн багтана) эдгээрийн материаллаг байдлын тухай судлан үзэж, материаллаг төсвийн шинжтэй ямар нэгэн шилжүүлгийг ил тод болгох үүрэгтэй.

Анхны баталгаажуулалтын үр дүн

Анхдугаар баталгаажуулалтаар 2.6 дугаар шаардлагыг ханган биелүүлэх чиглэлээр Монгол улс хангалттай хэмжээнд ахиц гаргаагүй хэмээн дүгнэгдсэн. Тухайн баталгаажуулалтын тайланд дурдсанаар Монголын ОУИТБС-ын 2014 оны тайланд төрийн өмч давамгайлсан 21 компанийн нэр, ТӨК болон Засгийн газар хоорондын шилжүүлэгт хамаарах зарим дүрэм журам болон зээл, зээлийн баталгаатай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хамрах хязгаарлагдмал мэдээллийг тусгажээ. Гэсэн ч баталгаажуулалтын дүнгээр ТӨК-иудын хуримтлагдсан ашиг, дахин хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой журам болон практик үйл ажиллагааг тайлбарлаагүй тул тус тайлан нь тухайн 2014 онд ТӨК-иудын эсвэл тэдгээрийн охин компаниудын эзэмшилд гарсан өөрчлөлтийг тодруулан дурдаагүй байна.

Анхдугаар баталгаажуулалтаар мөн Монгол улс нь 6.2 дугаар шаардлагыг биелүүлэхэд хангалттай бүс хэмжээнд хүчин чармайлт гаргасан хэмээн дүгнэжээ. Тухайн тайланд дурдсанаар Монголын ОУИТБС-ын 2014 оны тайлан нь зөвхөн төрийн өмчит нэг компанийн төсвийн шинжтэй зарцуулалтыг ил тод болгосон тул төсвийн шинжтэй зарцуулалтыг иж бүрэн хэмжээнд ил тод болгосон эсэх нь тодорхойгүй байна. Баталгаажуулалтаар мөн “ТӨК-иудын зүгээс орон нутгийн төрийн байгууллагад хийсэн төлбөрийг” ангилах тал дээр будилж, төрийн өмчит компаниудын зүгээс төрийн татаастай цахилгаан станцуудад нүүрс нийлүүлдэг ТӨК-ийн талаар бүгд мэддэг ч ОТОБ нь төсвийн шинжтэй зарцуулалт байдаг эсэхийг судлан үзээгүй байна.

Баталгаажуулалтаас хойш гарсан ахиц дэвшил

2.6 дугаар шаардлагатай хамааралтайгаар, Монголын ОУИТБС-ын 2016 оны тайланд ОТОБ нь 2016 онд Засгийн газарт материаллаг хэмжээний төлбөр хийсэн төрийн өмчит есөн компанийн цар хүрээг тодорхойлох илүү системтэй хандлагыг ашиглаж, тэдгээрийн төртэй харьцах хуулиар заасан харилцаа, үүнд гарсан зөрчил зэргийг дэлгэрэнгүй танилцуулжээ.

Материаллаг байдал: ОТОБ-ийн зүгээс гаргасан ТӨК¹³ хэмээх тодорхойлолтод нийцэх 19 компанийг тайланд тусгаж, эдгээрээс 2016 онд Засгийн газарт материаллаг төлбөр хийсэн хэмээн 9 ТӨК-ийг сонгон авсан үндэслэлээ тайлбарлажээ (хуудас.113). Өмнөх жилийн тайланд ТӨК хэмээх ангилалд

¹³ Шаардлага 2.6.а дээр хувьцааны дийлэнхийг эзэмшдэг, олборлох салбарт үйл ажиллагаа явуулдаг байх хэмээн заасан.

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээний төсөл

багтаж байсан 4 компанид¹⁴ төр зөвхөн цөөн хувийн хувьцаа эзэмшдэг тул энэ жил тайлангаас хассан байна.

Санхүүгийн харилцаа: Тайланд ТӨК болон Засгийн газар хороондын хуулиар тогтоосон санхүүгийн харилцааг¹⁵ тайлбарлаж, ТӨК нэг бүрийн ТУЗ нь ноогдол ашиг тараахтай холбоотой бодлогоо өөрийн сонголтоор гаргадаг бол зээлийн баталгаа, хувьцаа гаргахад Сангийн яамнаас бичгээр өгсөн зөвшөөрөлтэйгээр гаргах боломжтойг тайлбарлажээ (хуудас.116). Тайланд мөн 2016 онд практик дээр хэрэгжсэн ТӨК-иудын санхүүгийн харилцаа, материаллаг босго давсан 9 компанийн хуримтлуулсан ашиг, цэвэр ашиг/алдагдал болон ноогдол ашиг (хуудас.118-119), тухайн компанид хамаарах онцлог шилжүүлэг болон төсвийн шинжтэй зарцуулалт зэргийг оруулсан байна (хуудас.122-125). ОУИТБС-ын тайлан нь мөн 2016 оны 3 дугаар сард хийгдсэн Багануур ХК болон Багануур Повер (цахилгаан станц ажиллуулдаг) ХХК-ийн хооронд хийгдсэн, төрийн өмчит Багануурын эрчим хүчний төлөвлөж буй төслийн гуравдагч тал байдлаар хийгдсэн нүүрс худалдан авах концессийн гэрээг танилцуулсан байна (хуудас.119).

Эзэмшил: Тайлангаар мөн 15¹⁶ ТӨК-ийн товч танилцуулга, эдгээр дэхь төрийн өмчийн хувь хэмжээ (хуудас.113-116) зэргийг зааснаас гадна 2016 онд Засгийн газарт ямар нэгэн төлбөр хийгээгүй бусад 7 ТӨК¹⁷ буй талаар дурдсан байна (хуудас.116). 2016 онд Эрдэнэс Монгол ХХК шинэ 3 охин компани¹⁸ байгуулсаныг мөн дурджээ (хуудас.114, 120). Тайланд дурдсанаар 2016 онд Эрдэнэт дахь Монгол улсын төрийн эзэмшлийн 51%-д өөрчлөлт ороогүй ч ОХУ-ын төрийн өмчит Ростехнологи компани өөрийн эзэмшдэг 49%-ийг Монгол Зэс компанид 2016 оны 6 дугаар сард худалдсан байна (хуудас.120).

Зээл болон баталгаа: ОУИТБС-ын тайлангаар Засгийн газар (Хөгжлийн банкаар дамжуулан), ТӨК-иудын зүгээс олборлох салбарын компаниудад олгосон зээл, зээлийн баталгааг ил тод болгосон (хуудас.120-121) ажээ. Дэлгэрэнгүй мэдээллийн хүрээнд хийсэн гэрээний төрөл, эхлэх огноо, зээлийн хугацаа, хамаарах талууд, мөн хамаарах тайлбар зэргийг багтаажээ.

6.2 дугаар шаардлагын хувьд 2016 оны ОУИТБС-ны тайланд санаачилгын тайланд ашиглах зорилгоор төсвийн шинжтэй зарцуулалтыг тодорхойлохоор ОТОБ-ийн хийсэн ажлыг дурдаж, тухайн шилжүүлэгтэй ТӨК-иудын хийдэг ижил төстэй бусад шилжүүлгээс ялган тодорхойлсон байна (хуудас.122). ОТОБ нь компаниудын зүгээс бусад талуудад өгсөн хандив тусламжийн төсвийн шинжтэй шилжүүлэг хэмээн ангилан тайлагнаж байсан өмнөх туршлагадаа (2013-2015) үндэслэн төсвийн шинжтэй шилжүүлэг ил тод болгох босго дүнг 100 сая төгрөгөөр тогтоожээ (хуудас.123). Төрийн өмчит гурван компани¹⁹ төсвийн шинжтэй үйл ажиллагаа явуулсан тухайгаа мэдээлсэний тоонд Багануур ХК нь өөрийн төсвөөс татаастай үнээр цахилгаан станцуудад нүүрс нийлүүлсэн тухай, харин 6 компани ийм төрлийн үйл ажиллагаа явуулаагүй хэмээн тайлагнажээ (хуудас.123-125). 2016 оны ОУИТБС-ын тайланд дурдагдсан төсвийн шинжтэй зарцуулалтын мэдээллийг тухайн ТӨК-иудын ОУИТБС-д гарган өгсөн тайлан, тэдний аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаас авчээ.

¹⁴ Оюу Толгой, Гурвансайхан, Улаанбаатар төмөр зам чулуун завод болон Андын илч.

¹⁵ Монгол улсын төрийн болон хувийн өмчийн тухай хууль болон бусад журмуудаар зохицуулагддаг (жишээ нь Төрийн эзэмшлийг хэрэгжүүлэх журам гэх мэт).

¹⁶ Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс Таван Толгой, Эрдэнэс Оюу Толгой, Шивээ Овоо, Багануур ХК, Таван Толгой ХК, Мон Атом ХХК, Гашуун Сухайт ХХК, Эрдэнэс Метан ХХК, Эрдэнэс Шивээ Энержи ХХК, Эрдэнэт, МонголРосЦветмет ХХК, Могойн Гол ХК, Баянтээг ХЗ, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК.

¹⁷ Хорих 443 дугаар анги, СНТН, Авдрант хайрхан, Булган аймгийн хорих 439 дүгээр анги, Уул уурхайн аврах анги, Хэнтий аймгийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба, Шүүхийг шийдвэр гүйцэтгэх алба.

¹⁸ Эрдэнэс Ассет Менежемент болон Эрдэнэс Метан компанийн 100%, Эрдэнэс Шивээ Энержи компанийн 50%.

¹⁹ Багануур, Шивээ-Овоо, Эрдэнэс Монгол.

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээ

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ил тод байдлыг хангахтай холбоотой санал болгосон засан залруулах арга хэмжээнд Монгол улс хангалттай хэмжээнд анхаарал хандуулж, 2.6 дугаар шаардлагыг биелүүлэх чиглэлд хангалттай хэмжээнд ахиц гаргасан хэмээн дүгнэж байна. Монголын ОУИТБС-ын 2016 оны тайланд Засгийн газарт материаллаг төлбөр хийж буй 9 ТӨК-ийг багтааж, тэдгээр нь хуулийн дагуу төртэй ямар санхүүгийн харилцаатай байдаг, зээл, зээлийн баталгаа зэрэг болон тухайн жилд хуулиар тогтоосон харилцаанд гарсан томоохон зөрчил зэргийг тодорхой дурджээ. ОТОБ нь Эрдэнэс Монгол болон Олон улсын санхүүгийн корпораци, Олон улсын валютын сан болон Азийн хөгжлийн банк зэрэг техникийн туслалцаа үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллаж 2.6 дугаар шаардлагад дурдсан мэдээллийг (жишээ нь ТӨК-ийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан) ил тод болгох чиглэлээр ажиллавал үр дүнтэй байх юм.

Төсвийн шинжтэй зарцуулалттай холбоотой засан залруулах арга хэмжээнд анхаарал хандуулан арга хэмжээ авсанд Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар нь сэтгэл ханамжтай байж, 6.2 дугаар шаардлагыг ханган биелүүлэх чиглэлээр Монгол улс хангалттай хэмжээнд ахиц дэвшил гаргасан хэмээн үзэж байна. ОУИТБС-ын 2016 оны тайлан нь ОТОБ-ын зүгээс гаргасан “төсвийн шинжтэй зарцуулалтын” тодорхойлолт (ОУИТБС-ын стандартад нийцсэн), үүний материаллаг байдлын өөрийн хийсэн үнэлгээ болон ТӨК-иудын зүгээс 2016 онд хийгдсэн, нэг талаас тайлагнасан материаллаг төсвийн шинжтэй зарцуулалтын тайлан зэргийг тусгасан байна. Санаачилгын хэрэгжилтийг сайжруулахын тулд ОТОБ нь төсвийн шинжтэй зарцуулалтыг Сангийн яамны вебсайт эсвэл Монголын ОУИТБС-ын мэдээллийн портал зэрэг төрийн байгууллагуудын ашигладаг системд төлөвшүүлэн байнга мэдээлж байх зорилгоор төсвийн шинжтэй зардлын хамрах цар хүрээг илүү өргөн хүрээнд тогтоож болох юм.

3.4 Засан залруулах арга хэмжээ 4

4.5 дугаар шаардлагад заасанчлан ОТОБ нь тайлан гаргах үйл явц нь материаллаг байдлыг үнэлж, орон нутгийн төрийн байгууллагуудад хийгдсэн материаллаг төлбөрийг иж бүрнээр ил тод болгох шаардлагатай.

Анхны баталгаажуулалтын үр дүн

Өмнө хийгдсэн анхдугаар баталгаажуулалтаар энэхүү шаардлагыг биелүүлэх чиглэлээр Монгол улс нь тодорхой хэмжээний ахиц гаргасан хэмээн дүгнэжээ. Тайланд дурдсанаар ОТОБ нь ТӨК-иуд болон Засгийн газар хоорондын шилжүүлгүүдийг судлан үзэж, олборлох үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй 21 ТӨК-ийн төлсөн ноогдол ашгийн мэдээллийг ил болгожээ. Гэхдээ баталгаажуулалтын дүгнэснээр ОУИТБС-ын 2014 оны тайлан нь ТӨК-иудын зүгээс орон нутгийн захиргаадад хийгдсэн төлбөрийг багтаасан ч “орон нутагт хийгдсэн шүүд төлбөр” болон “орон нутагт хийгдсэн төлбөр” хэмээх ангиллын хооронд андуурал гарсан хэмээн үзжээ.

Баталгаажуулалтаас хойш гарсан ахиц дэвшил

*Олборлох салбарын компаниудиа*с ТӨК-иудад хийсэн төлбөрийн хувьд 2016 оны ОУИТБС-ын тайлан нүүрс болон эрчим хүч худалдан авах зорилгоор төрийн өмчит 4 компанид хийсэн хувийн компаниудын шилжүүлгийг оруулсан (хуудас.122) ч эдгээр нь ТӨК-д хийгдсэн татвар эсвэл төлбөр бус харин арилжааны зорилгоор хийсэн төлбөр байна.

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээний төсөл

ТӨК-иудаас Засгийн газарт хийсэн төлбөрийн хувьд тайлан дээр ТӨК-д хамаарах онцлог төлбөр (ноогдол ашиг), бүх компаниудын төлдөг хуулиар тогтоосон төлбөр, улсын төсөвт бүртгэгдсэн төсвийн шилжүүлэг, төсвийн шинжтэй зарцуулалт болон орон нутагт шууд төлөх төлбөр зэргийг тодорхой байдлаар ангилан ялгаж өгчээ (хуудас.122-124). Тайлан гаргасан 9 ТӨК-ийн 6 нь зарим төрлийн ТӨК хоорондын эсвэл Засгийн газарт төлсөн төлбөрийн тайлагнасны тоонд зээлийн эргэн төлөлт, удирдлагын зардал болон торгууль зэрэг байна (хуудас.122). Тайлан нь материаллаг босгоос дээш хэмжээний төлбөр төлсөн 9 ТӨК-ийн 4-ийнх нь төлсөн хэмээн тайлагнасан ноогдол ашгийн үнэн дүнг ил тод болгосон (хуудас.118-119) ч тухайн ТӨК-ийн тараасан ноогдол ашиг нь орлогын урсгалыг сонгох материаллаг босгоос хэтрээгүй тул нэгтгэлд хамруулаагүйг дурджээ (хуудас.119). Тайлан нь мөн ТӨК-ийн орон нутгийн шууд төлбөр (хуудас.126) болон төсвийн шинжтэй зарцуулалтын (хуудас.123-125) дэлгэрэнгүй мэдээллийг харуулжээ.

Засгийн газрын зүгээс ТӨК-д хийсэн төлбөрийн хувьд ОУИТБС-ын 2016 оны тайлан нь 2016 онд Засгийн газрыг зүгээс төрийн өмчит гурван компанид олгосон зээлийн дүнг дурдаж (хуудас.120-121) Засгийн газраас ТӨК-иудад хийгдсэн бүх шилжүүлэг нь улсын төсвийн гүйцэтгэлийн тайланд бүртгэгдсэн болохыг дурджээ (хуудас.122). 2016 оны тайлан нь 2016 оны улсын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн холбоосыг заагаагүй ч энэхүү мэдээлэл нь Шилэн дансны вебсайт дээр олон нийтэд нээлттэй байна.²⁰

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээ

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн шилжүүлэгтэй холбоотой ил тод байдлыг хангахын тулд авч хэрэгжүүлсэн засан залруулах арга хэмжээнд сэтгэл хангалуун буй бөгөөд Монгол улс нь 4.5 дугаар шаардлагыг ханган биелүүлэхэд хангалттай хэмжээний ахиц гаргасан хэмээн үзэж байна. ОУИТБС-ын 2016 оны тайлан нь ТӨК-д хамааран онцлог шилжүүлгийг ТӨК-ийн бусад төрлийн шилжүүлгээс (жишээ нь энгийн татвар) тодорхой ялган зааж өгсөн байна. Ноогдол ашиг нь ОТОБ-ын зүгээс орлогын урсгалыг сонгоход зориулан тогтоосон материаллаг босгоос доогуур хэмжээнд байсан тул нэг тал дангаар тайлагнасан. Санаачилгын хэрэгжилтийг цаашид сайжруулахын тулд ОТОБ нь ТӨК-д хамаарах онцлог шилжүүлгийг төрийн байгууллагын түгээмэл систем эсвэл ОУИТБС-ын мэдээллийн порталаар дамжуулан ил тод болгож байх арга замыг эрэлхийлбэл зүйтэй болно.

3.5 Засан залруулах арга хэмжээ 5

ОУИТБС-ын 4.9.b.iii дугаар шаардлага болон ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн баталсан Хараат бус нэгтгэгчийн Гүйцэтгэх ажлын стандарт даалгаварын дагуу ОТОБ болон Хараат бус нэгтгэгч нь доорх үүргийг хүлээнэ:

а. ОУИТБС-ын тайлан гаргах үйл явцад оролцож буй компани болон төрийн байгууллагуудын аудитын болон баталгаажуулалтын журмыг шинжлэн шалгаж, үүн дээр үндэслэн гарган өгч буй мэдээлэл нь 4.9 дүгээр шаардлагын дагуу үнэн зөв, итгэл төрүүлэхүйц болохыг баталгаажуулах зорилгоор оролцогч компаниуд болон төрийн байгууллагууд ямар мэдээллийг Хараат бус нэгтгэгчид гарган өгөх шаардлагатай болохыг зөвшилцөн гаргасан байна. Хараат бус нэгтгэгч нь ОУИТБС-ын иж бүрэн, найдвартай тайлан гаргах үндэс суурийг бий болгохын тулд хяналт хийж, хамаарах мэргэжлийн стандартыг ашиглан журам процедурыг гаргасан байна. Хараат бус нэгтгэгч нь өөрийн мэргэжлийн чадварыг ашиглан компани болон төрийн байгууллагуудын тухайн үед хэрэгжүүлж буй хяналт болон аудитын хүрээлэлд найдаж болох цар хүрээг тогтоон гаргана. Хараат бус нэгтгэгчийн эхлэлийн тайлан нь судлан үзсэн сонголтууд болон хийгдэх баталгаажилтын үндэслэлийг дурдсан байна.

²⁰ Шилэн дансны вебсайтыг үзнэ үү, 2016 оны улсын төсвийн гүйцэтгэл, 2018 оны 1 сарын байдлаар [энд](#) үзнэ үү.

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээний төсөл

б. Хараат бус нэгтгэгч нь гарган өгсөн санхүүгийн мэдээллийн иж бүрэн болон найдвартай байдалд үнэлгээ хийж, үүнд Хараат бус нэгтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлын талаар мэдээллийн чанартай тойм, тухайн хийсэн үнэлгээний хязгаарлалтуудыг багтаасан байна.

в. Хараат бус нэгтгэгч нь ОУИТБС-ын тайлан гаргах үйл явцын харилцан зөвшилцөн тогтоосон цар хүрээнд хамаарах бүх компани болон төрийн байгууллага хүсэмжилсэн мэдээллийг гарган ирүүлсэн эсэхийг шалган баталгаажуулна. Хараат бус нэгтгэгчид тайлагнахад гарсан ямар нэгэн орхигдол, сул талуудыг ОУИТБС-ын тайланд ил тодоор мэдээлж, үүнд гаргасан журмыг даган мөрдөөгүй байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, энэ нь тайлангийн иж бүрэн байдалд материаллаг нөлөөлөл үзүүлж болох эсэхэд хийсэн үнэлгээ зэргийг багтаана.

Анхны баталгаажуулалтын үр дүн

Анхны баталгаажуулалтаар энэхүү шаардлагыг ханган биелүүлэх чиглэлээр тодорхой хэмжээний ахиц дэвшил гаргасан хэмээн дүгнэлт гаргажээ. Баталгаажуулалтын тайланд дурдахдаа чанарын баталгаажуулалтын журмыг зөвшилцөн батлахаас өмнө аудитын практик дээр хяналт хийж байгаагүй болохыг тэмдэглэжээ. Баталгаажуулалтаар мөн мэдээллийн чанарын баталгаажилтын асуудлууд нь (компани болон Засгийн газрын) 2014 оны ОУИТБС-ын тайланд ихээхэн хэмжээнд дурдагдсан байна. 2014 оны ОУИТБС-ын тайланг бэлтгэхэд ашигласан Цахим тайлангийн систем нь ОУИТБС-ын санхүүгийн нэгтгэл мэдээллийн нууцлалын асуудлыг гарган ирж байсан ч мэдээллийн чанарын баталгаажилттай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн эсэх нь харагдахгүй байна. 2014 оны ОУИТБС-ын тайлан нь чанарын баталгаажилтын тухай тоймыг дурдсан ч тайлан гаргагч компаниуд болон төрийн байгууллагын орхигдуулсан дүнгийн материаллаг байдалд үнэлгээ хийгээгүй ажээ.

Баталгаажуулалтаас хойш гарсан ахиц дэвшил

Монголын ОУИТБС-ын 2016 оны тайлан нь нэгтгэлд хамрагдсан мэдээллийн чанарын баталгаажилтын талаар илүү хэмжигдэхүйц аргачлалыг баримтлахаар ОТОБ зөвшилцсөн болохыг тэмдэглэжээ. Хуралдааны тэмдэглэл зэрэг Монголын ОУИТБС-ын баримт бичгүүдээс үзвэл ОТОБ нь Үндэсний зөвлөлийн баталсан загварын дагуу гаргасан Гүйцэтгэх ажлын даалгаварын дагуу Хараат бус нэгтгэгчийг сонгон шалгаруулж, баталгаажуулсныг тусгажээ.

Аудитын практик: Тайлан нь төр болон хувийн хэвшлийн байгууллагуудын аудит болон баталгаажилттай хамаарах хуулиар тогтоосон журмыг тайлбарлаж, олон улсын стандартад үл нийцсэн тохиолдлыг тодруулан гаргасан байна. Тус тайланд 1997 онд батлагдсан Монгол улсын аудитын тухай хуулинд 2015 онд хийгдсэн нэмэлт өөрчлөлтөөр зарим компаниудад тавигдах аудитын шаардлагуудыг хөнгөлсөн тухай тайлбар өгч (хуудас.62-63), мөн Ерөнхий аудиторын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн (орлогын бус) тайланг дэлгэрэнгүй танилцуулж, хамаарах холбоосыг 2016 оны тайланд оруулжээ (хуудас.107, 111). Тайланд мөн ТӨК-иуд нь аудитаар баталгаажсан хоёр тайлантай- нэг нь хараат бус аудиторын хийсэн дэлгэрэнгүй тайлан, нөгөө нь УАГ-ын хийсэн ерөнхий тайлан байна. Материаллаг босго давсан 9 ТӨК-ийн зургаа нь УАГ-ын хийсэн 2016 оны аудитын тайлангийн хувийг гарган өгсөн (хуудас.118, 121). Тайланд мөн 2016 онд нэгтгэлд хамрагдсан, материаллаг босго давсан 213 компанийн 146 нь өөрсдийн 2016 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг гарган өгсөн бол тайлан гаргасан компаниудын 97% нь шаардлага үл хангах аудиторын саналыг ирүүлжээ (хуудас.45-46). Хавсралт 12 дээр материаллаг босго давсан 213 компанийн аудиторын дүгнэлтүүдийг жагсаан оруулжээ (х/хуудас.28-31).

Баталгаажуулалтын арга зүй: Тайланд дурдсанаар Хараат бус нэгтгэгч нь нэгтгэлд хамрагдаж буй мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлын баталгаажуулалт чиглэлээр төрийн байгууллагуудаас илүүтэйгээр компаниудад илүү төвлөрөн ажиллаж ирсэнийг тэмдэглэжээ (хуудас.33). Олборлох салбарын компаниуд болон төрийн байгууллагуудаас шаардаж буй чанарын баталгаажуулалт нь

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээний төсөл

тайлагнасан төлбөрүүд/орлогыг шилжүүлэг нэг бүрээр задлан ирүүлэх, компанийн ахлах удирдлага эсвэл төрийн байгууллагын удирдлагаас (эсвэл Сайд) албан ёсны баталгаа гаргуулах болон боломжтой бол компанийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан эсвэл аудитын тайлан зэргийг багтааж буй юм (хуудас.16-17, 27, 30, 41, 45, 46). 2016 оны эхлэлийн тайланд судлан үзсэн олон төрлийн сонголтууд болон тайлан гаргалтад ашиглахаар зөвшилцсөн чанарын баталгаажилтын төрлийн үндэслэл зэргийг тодорхой дурджээ.²¹ ОУИТБС-ын 2016 оны тайлан нь мэдээллийн найдвартай байдлыг баталгаажуулах үйл явцын тайлбарлаж, даган мөрдөөгүй компаниудын төлбөрийн материаллаг байдал, үүнээс нэгтгэлийн баталгаатай байдалд үзүүлж буй нөлөөлөлд үнэлгээ хийсэн байна (хуудас.21-22, 27-32). Нийтдээ 213 компанийн 24 нь өөрийн тайланд орсон мэдээллийн баталгааг гарган ирүүлээгүй ажээ (хуудас.17). Тайланд дурдсанаар эдгээр 24 компаниуд нь төрийн зүгээс тайлагнасан олборлох салбарын нийт орлогын 0.5%-ийг эзэлж байна (хуудас.31). Компаниудын зүгээс шаардсан чанарыг баталгаажилтыг гарган өгөөгүй шалтгаан, жишээ нь зарим компани татан буугдсан болон тухайн шаардлагуудын талаарх ойлголт дутмаг байх зэрэг шалтгаануудыг тайланд мөн оруулжээ (хуудас.44-45). Хараат бус нэгтгэгч тухайн шаардлагыг биелүүлээгүй компаниудтай өргөн хүрээнд ажиллаж (утсаар ярих, цахим шуудан илгээх) байсан тухай товч оруулжээ (хуудас.44-45). Хавсралт 4-5 дээр материаллаг босго давсан компани, төрийн байгууллагуудын тайлагналын үр дүнг (х/хуудас.5-8) харуулж, 166 компани төлөөллийн захидал ирүүлээгүйг заажээ (хуудас.45-46). Нийтдээ энэхүү тайлан нь 2014, 2015 болон 2016 онуудын ОУИТБС-д тайлагнасан мэдээллийн найдвартай байдал дээр томоохон ахиц гарсныг харуулсан ба 2016 оны тайлан дахь нийт орлогын 57% дээр дунд/доогуур түвшний баталгаажуулалттай, 42% нь өндөр түвшний баталгаажуулалттай байна (хуудас.31-32).

ОУИТБ-ын өмнөх тайлангуудын нэгэн адил ОТОБ нь Хараат бус нэгтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авалтын журмыг баталж, улмаар сонгогдсон Хараат бус нэгтгэгч нь өөрийн үүрэгт ажлаа ISRS 4400 буюу Хамаарах үйлчилгээний олон улсын стандарт болон ОТОБ-ийн батлан гаргасан Гүйцэтгэх ажлын даалгаварын дагуу гүйцэтгэжээ (хуудас.8). Баталгаажуулалтын журмын талаарх ОТОБ-ын хүрсэн зөвшилцлийг шууд дурдсан байна (хуудас.27). Тайланд мөн төрийн байгууллагуудын гаргасан тайланд 2018 онд YAГ-аар баталгаа гаргуулах чиглэлээр ОТОБ-ын авч хэрэгжүүлсэн онд хүчин чармайлтыг (хуудас.148) дурдсан ч үүнд YAГ-ын санал болгож буй аргачлалын талаарх Хараат бус нэгтгэгчийн зүгээс гаргасан мэргэжлийн тайлбарыг оруулаагүй байна.

Найдвартай байдлын үнэлгээ: ОУИТБС-ын тайланд нэгтгэлд хамрагдсан мэдээллийн баталгаажилтыг үндсэндээ компаниудын гарган өгсөн баталгаажилтад үндэслэн хамруулсанаас нийт нэгтгэлийн мэдээллийн 0.94% нь л “доод” түвшний баталгаагаажуулалт бүхий мэдээлэл буй тул нэгтгэлд хамрагдсан мэдээллийн үнэн зөв найдвартай байдал, иж бүрэн байдлыг “хангалттай” хэмээн үзэж байна (хуудас.10, 33).

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээ

ОУИТБС-ын тайлангийн нэгтгэлд хамрагдаж буй мэдээллийн найдвартай байдлын чиглэлд санал болгосон засан залруулах арга хэмжээнд анхаарал хандуулж, 4.9 дүгээр шаардлагыг биелүүлэхэд хангалттай хэмжээний ахицыг Монгол улс гаргаад байна хэмээн Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар үзэж байна. ОУИТБС-ын 2016 оны тайлан нь нэгтгэлд хамрагдсан мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангасан аргачлалын талаар дэлгэрэнгүй тайлбарлаж, үүнд аудитын хяналт болон баталгаажуулалтын журам, практикыг судалсан байдал, баталгаажуулалтын журмын тайлбар,

²¹ Монголын ОУИТБС (2017 оны 6 сар), ‘ОУИТБС-ын 2016 оны нэгтгэлийн эхлэлийн тайлан’, нийтлэгдээгүй, Монголын ОУИТБС-ын Ажлын албанаас гарган өгсөн, хуудас.22-30.

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээний төсөл

тухайн шаардлагыг даган мөрдөөгүй байгууллага аж ахуйн нэгжийн материаллаг байдал зэргийг багтаажээ. Тайланд Хараат бус аудиторын зүгээс нэгтгэлд хамруулсан мэдээллийн иж бүрэн байдал, үнэн зөв найдвартай байдалтай холбоотойгоор гаргасан тодорхой мэдэгдлийг мөн оруулжээ.

3.6 Засан залруулах арга хэмжээ 6

5.2.а шаардлагын дагуу ОТОБ нь ТӨК-иудын орон нутагт шууд төлж буй төлбөр болон орон нутгийн шилжүүлгийн ялгааг мэдээлэл цуглуулж эхлэхээс өмнө урьдчилан тодорхой болгосон байх үүрэгтэй. ОТОБ нь ОУИТБС-ын тайлан нь аймаг болон сумдад хийгдсэн шилжүүлгийн орлого хуваалцах томъёог харуулж, орон нутгийн шилжүүлгийн төсөвлөсөн дүн болон гүйцэтгэлд гарч буй зөрүүг ил тод болгосон байна.

Анхны баталгаажуулалтын үр дүн

Монгол улсад хийгдсэн анхдугаар баталгаажуулалтаар энэхүү шаардлагыг хангахын тулд Монгол улс тодорхой хэмжээнд ахиц дэвшил гаргаад буй хэмээн дүгнэжээ. Баталгаажуулалтын тайланд дурдсанаар 2014 оны ОУИТБС-ын тайланд орон нутгийн шилжүүлгийг тооцох ерөнхий томъёог оруулсан ч аймаг болон сумдын шилжүүлэг тооцох томъёог оруулаагүй буйг дурджээ. Баталгаажуулалт нь бодит болон тооцсон шилжүүлэг хоорондын зөрүүг ил тод болгоогүй хэмээн үзсэн байна.

Баталгаажуулалтаас хойш гарсан ахиц дэвшил

Монголын ОУИТБС-ын 2016 оны тайланд орон нутагт хийсэн 2 төрлийн шилжүүлэг болох ашигт малтмал/газрын тосны нөөцийн төлбөр (рояалти) болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж буйг тайлбарлажээ (хуудас.100-105). Эхний төрлийн шилжүүлэг нь Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрөн, улмаар аймаг сумдын Орон нутгийн хөгжлийн сангуудад шилжиж буй бол хоёрдахь шилжүүлэг нь улсын төсвөөс (Сангийн яам) шууд Орон нутгийн хөгжлийн сангуудад хийгдэж байна (хуудас.100). Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн санхүүжилт нь нийт бараа, үйлчилгээнд ноогдуулсан НӨАТ-ын (импортод ноогдсон татвар орохгүй) 10%, ашигт малтмалын нөөцийн төлбөрийн 50%, газрын тосны нөөцийн төлбөрийн 30%-иас бүрдэж байна (хуудас.100). Түүнчлэн “мега төслүүдийн орлогын” 30%, ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50% энэхүү санд төвлөрч байна (хуудас.100). Тус тайланд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангуудын хөрөнгө шилжүүлэг нь улсын төсвөөс аймгуудад, улмаар аймгаас сумдад хуваарилагддаг болохыг тодорхой дурджээ (хуудас.100). ОТОБ нь орон нутгийн шууд шилжүүлэн, орон нутгийн шилжүүлэн, нийгмийн зарцуулалт болон ТӨК-иудын төсвийн шинжтэй зарцуулалт хоорондын ялгааг тодорхойлон гаргасан болох нь нотлогдож байна (хуудас.122-126).

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь өөрийн Орон нутгийн хөгжлийн сан бүхий 21 аймгийн санхүүжилтын томоохон эх үүсвэр болдог. Тайлан дээр Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн бүх шилжүүлэг болон Орон нутгийн хөгжлийн сангийн шууд шилжүүлэг нь юуны өмнө аймгийн түвшин дэхь Орон нутгийн хөгжлийн санруу хийгдэж, улмаар тус сангаас сум түс бүрт хуваарилагдсан хөрөнгийг шилжүүлдэг ажээ (хуудас.100). Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн санхүүжилтыг²²

²² Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь импортын бус бараа, үйлчилгээнд ноогдуулсан НӨАТ-ын 10%, ашигт малтмалын нөөцийн төлбөрийн орлогын 5%, газрын тосны нөөцийн төлбөрийн 30%, дотоодын төрийн бус байгууллагуудын олгосон тэтгэлэг санхүүжилт, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий албан ёсны гадаадын тусламж болон доод шатны сангаас дунд шатны санд хийх шилжүүлэг зэргээс бүрддэг.

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээний төсөл

тооцох ерөнхий томъёо болон Орон нутгийн хөгжлийн санхүүжилтын хөрөнгийг тооцох ерөнхий томъёог²³ тусгажээ (хуудас.100). Томъёоны дагуу Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нугийн хөгжлийн сангуудад хийгдэхээр төлөвлөгдсөн болон бодитоор хийгдсэн шилжүүлгийн дүнг нэгдсэн сан болон орон нутгийн сангуудын орлогоор нэгтгэн харуулсан байна (хуудас.100). Дээрх дүнгүүд хоорондын зөрүүг тодорхойлсон ч 2016 онд ашигласан томъёогоор тооцвол бодитоор төвлөрүүлсэн орлого нь төлөвлөсөн орлогоос өндөр байна (хуудас.100).

Тайланд мөн Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгуудад хөрөнгө хуваарилах дэлгэрэнгүй томъёо²⁴ болон дөрвөн томъёоны хувьсагч бүрийн төрийн санхүүжилтын эх үүсвэр (хуудас.102) зэргийг багтаажээ.²⁵ Сангийн яам нь тэрхүү томъёог ашиглан Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн болон Орон нутгийн хөгжлийн сангуудад шууд төлөвлөсөн хөрөнгийг тооцдог болохыг тайланд дурджээ (хуудас.104). Тайлан нь Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Орон нутгийн хөгжлийн сангуудад шилжүүлсэн хөрөнгийн хэмжээ болон Орон нутгийн хөгжлийн сангуудын шууд шилжүүлгийн дүнг тухайн томъёоны дагуу 2016 онд төлөвлөсөн болон бодит гүйцэтгэлээр нь харуулжээ (хуудас.101, 103-104). Хавсралт 23.а дээр аймаг бүрийн Орон нутгийн хөгжлийн сангаас 2016 онд сумдад шилжүүлсэн мөнгөн дүнг 21 аймаг нэг бүрээр тайлагнасан бол (х/хуудас.109-111) Хавсралт 23.б нь Сангийн яамны орон нутгийн хөгжлийн сангийн тайлангийн платформ²⁶ дээрээс авсан сүм бүрт шилжүүлсэн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг, гарсан зөрүүний хамтаар нийтэлсэн байна (х/хуудас.112-116). 2016 оны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгөнд УАГ-ын зүгээс хийсэн нийцлийн аудитын тайланг²⁷ мөн дурдсаны зэрэгцээ тухайн тайланд дурдсан асуудлуудын товч тоймыг мөн тайланд багтаажээ (хуудас.105).

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээ

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар нь орон нутгийн шилжүүлэгтэй хамаарах засан залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэмээн тооцож, Монгол улс нь 5.2 дугаар шаардлагыг ханган биелүүлэх чиглэлд хангалттай ахиц гаргасан хэмээн үзэж байна. ОУИТБС-ын 2016 оны тайлан нь Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгуудын Орон нутгийн хөгжлийн санд хийгдэх шилжүүлэг, мөн Сангийн яамны зүгээс ашигт малтмалын нөөцийн төлбөраас аймгуудын Орон нутгийн хөгжлийн санд хийгдэх шууд шилжүүлгийг тооцох дэлгэрэнгүй томъёог багтаажээ. Томъёоны дагуу төлөвлөсөн орон нутгийн шилжүүлгийн дүн болон 2016 оны бодит гүйцэтгэлийг шууд хүлээн авагч болох аймаг, дам хүлээн авагч болох сумдаар нь гаргажээ. Төлөвлөсөн болон бодит шилжүүлэг хоорондын зөрүүний учир шалтгааны ерөнхийлөн тайлагнахын зэрэгцээ мэдээллийг аймаг, сумдаар задлан харуулсан нь орон нутгийн түвшин дэхь олборлох салбарын орлогыг судлан шинжлэх боломжийг олгож байна.

²³ Орон нутгийн сан нь мега төслүүдийн орлогын 30% болон ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50%-иар санхүүждэг.

²⁴ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Орон нутгийн хөгжлийн сангуудад хийгдэх шилжүүлгийн тооцоо нь нэг бүрийн 25% жигнэсэн дундаж бүхий үндсэн 4 хувьсагчаас шалтгаалах бөгөөд эдгээр нь; хүн ам; хүн амын нягтаршил, алслагдсан байдал болон газар нутгийн хэмжээ; болон орон нутгийн татварын санаачилга зэрэг байна.

²⁵ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Орон нутгийн хөгжлийн сангууд болон орон нутагт дахь сангуудад шууд хийгдэх шилжүүлгийг тооцох томъёо нь аймаг бүр дээр 4 хувьсагчтай байна: орон нутгийн хүн амын хөгжлийн индекс; хүн амын тоо; хүн амын нягтаршил, алслагдсан байдал болон газар нутгийн хэмжээ; болон орон нутгийн татварын санаачилгуудын индекс оноо зэрэг байна. Аймаг бүрийн 4 хувьсагчтай хамаарах мэдээллийг Сангийн яам, Татварын ерөнхий газар болон аймгуудын ИТХ-аас авч болно. Үүнийг ОУИТБС-ын 2016 оны тайланд баталгаажуулж, томъёо болон хувьсагч нэг бүрийн утгыг 21 аймаг харуулсан (хуудас.102-103).

²⁶ Сангийн яамны Орон нутгийн хөгжлийн сангийн тайлангийг платформын холбоос өгөгдсөн, 2018 оны 1 сарын байдлаар [эндээс](#) үзнэ үү.

²⁷ УАГ (2017), 'Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн 2016 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлан', 2018 оны 1 сарын байдлаар [энд](#) үзнэ үү.

3.7 Засан залруулах арга хэмжээ 7

Шаардлага 6.1.а дээр заасны дагуу ОТОБ нь мэдээлэл цуглуулж эхлэхээс өмнө заавал тайлагна болон сайн дурын үндсэн дээр тайлагнах нийгмийн зарцуулалтууд хоорондыг ялгаа заагийг тодорхойлон гаргасан байх үүргийг хүлээнэ. Заавал тайлагнах нийгмийн зарцуулалт мөнгөн бус хэлбэрээр хийгдсэн бол ОТОБ нь тухайн зарцуулалтын зориулалт, мөнгөн дүнгээр илэрхийлсэн үр дүнг ил тод болгосон байна. Хэрэв заавал тайлагнах нийгмийн зарцуулалтын хүлээн авагч нь төрийн байгууллага бус харин гуравдагч тал бол ОТОБ нь тухайн хүлээн авагчийн нэр болон үндсэн чиг үүргийг ил тод мэдээлнэ.

Анхны баталгаажуулалтын үр дүн

Анхны баталгаажуулалтаар энэхүү шаардлагыг хангах чиглэлээр Монгол улс тодорхой хэмжээний ахиц гаргасан хэмээн дүгнэжээ. ОТОБ нь нийгмийн зарцуулалтыг дэлгэрэнгүй байдлаар харгалзан үзэж, эдгээрийг 2013 болон 2014 оны ОУИТБС-ын тайланд ил тод болгон нийтэлсэн ч баталгаажуулалтаар заавал болон сайн дурын үндсэн дээр тайлагнах нийгмийн зарцуулалт хоорондын ялгаа заагийг тусгайлан гаргаагүй, харин тайлан гаргагч байгууллагууд өөрсдийн үзэмжээр зааглан тайлагнаж байна хэмээн үзсэн байна. Тиймээс заавал тайлагнах нийгмийн зардлын ил тод байдлын иж бүрэн байдал тодорхойгүй байна. Мөнгөн бус зарцуулалтын зориулалт болон үндэслэлийг тайлбарлаагүй, хүлээн авсан төрийн бус байгууллагын нэр зэрэг дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй.

Баталгаажуулалтаас хойш гарсан ахиц дэвшил

ОУИТБС-ын 2016 оны тайланд сайн дурын болон заавал тайлагнах нийгмийн зардлын хоорондыг ялгаа заагийг гаргаж, үүнийг мэдээлэл цуглуулах ажил эхлэхээс мөн батлан хэрэгжүүлж, эхлэлийн тайланд тусгасан байна (хуудас.136). ОТОБ нь заавал тайлагнах нийгмийн зарцуулалтыг ил тод болгож, нэгтгэлд хамруулах шийдвэр гаргасан бөгөөд нийгмийн зарцуулалтыг хуулиар эсвэл гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хийгдэж буй, материаллаг босго тэг төгрөгөөс дээш зарцуулалт хэмээн тодорхойлжээ (хуудас.136). Тайланд ТӨК-ийн орон нутагт хийх шууд төлбөр, орон нутгийн шилжүүлэг, нийгмийн зарцуулалт болон төсвийн шинжтэй зарцуулалт хоорондыг ялгааг зөв зохистойгоор гаргажээ (хуудас.122-126). Зарим ТӨК бартераар гүйцэтгэж буй дэд бүтцийн төслүүд эсвэл дэд бүтэц барьж байгуулсан тухайгаа тайлагнасан ба тайлан дээр нийгмийн зарцуулалт хэмээн ангилсан ч Засгийн газрын зүгээс тогтоосон нөгөө талынх нь эх үүсвэр тодорхойгүй байна (хуудас.134, 135).

ОУИТБС-ын тайлан нь 15 компанийн тайлагнасан заавал тайлагнах нийгмийн зардлуудыг нэгтгэлд хамруулан үр дүнг нь тусгасан ба эдгээр нь нийт нэгтгэлд хамрагдсан заавал тайлагнах нийгмийн зарцуулалтын 96%-ийг эзэлж, нэгтгэлээр багахан хэмжээний зөрүүтэй гарсан байна (хуудас.136-139, х/хуудас.133-135). Нэгтгэлд хамруулсан заавал тайлагнах нийгмийн зарцуулалтын дэлгэрэнгүй мэдээлэл нь мөнгөн болон мөнгөн бус зарцуулалтыг ялган зааглаж, мөнгөн бус зарцуулалтын зориулалт, утгыг зааж, хүлээн авагч аймаг, сумыг мөн оруулсан байна (хуудас.136-139, х/хуудас.133-135). Заавал тайлагнах нийгмийн зарцуулалтыг хүлээн авсан тал болох төрийн бус байгууллагуудыг мөн тайланд дурджээ (хуудас.138-139).

ОТОБ нь мөн материаллаг босго давж буй (хувийн компанийн хувьд Шилэн дансны тухай хуулинд заасны адил материаллаг босго нь 5 сая төгрөг, ОТОБ-ын зүгээс ТӨК-иуд дээр түлхүү төвлөрч буй тул 1 сая төгрөг) компаниудын зүгээс дангаар ил тод болгосон нийгмийн зарцуулалтыг тайланд оруулахаар шийдсэн байна (хуудас.136). Сайн дурын үндсэн дээр нийгмийн зарцуулалтаа тайлагнасан 26

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгэний төсөл

компанийн мэдээллийг бэлэн мөнгө болон бэлэн бус зарцуулалтаар нь задлан, тухайн хийсэн төлбөрийн зориулалт, хүлээн авагч сумын мэдээлэл зэргийн хамт тусгажээ (хуудас.139, х/хуудас.136).

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээ

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар нь нийгмийн зарцуулалтыг ил тод болгохтой засан залруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэнд сэтгэл ханамжтай буйн зэрэгцээ 6.1 дүгээр шаардлагыг хангахад хангалттай хэмжээний, үүнээс ч илүү хэмжээний ахиц гаргасан хэмээн дүгнэж байна. Монголын ОУИТБС-ын 2016 оны тайланд заавал болон сайн дураар тайлагнах нийгмийн зарцуулалтыг тодорхой ялгаатай тогтоож, ТӨК-иудын төсвийн шинжтэй зарцуулалт зэрэг бусад төрлийн төлбөрөөс ялгаж өгсөн байна. Заавал тайлагнах нийгмийн зарцуулалтыг нэгтгэн тулгалт хийсэн ОТОБ-ийн үр дүнг тусгасан, зарцуулалтыг бэлэн болон бэлэн бусаар нь задалсан (бэлэн бус хэлбэрээр хийсэн төлбөрийн зориулалт болон үнэ цэнэ), хүлээн авсан төрийн бус байгууллагуудын заримыг дурджээ. ОТОБ нь мөн компаниудын сайн дураар, зөвхөн нэг талаас тайлагнах материаллаг нийгмийн зарцуулалтын цар хүрээг компани бүрээр оруулж, үр дүнг 2016 оны ОУИТБС-ын тайланд оруулсан байна.

3.8 Засан залруулах арга хэмжээ 8

Шаардлага 7.4.a.iii, 7.4.a.iv болон 7.4.b дээр заасны дагуу ОТОБ нь дараа жилийн ажлын явцын тайланг бэлтгэхэд ОУИТБС-ын зөвлөмжүүдийн хэрэгжилт, хэрэгжилтээс үзүүлж буй нөлөөлөл дээр үнэлгээг өргөн хүрээний оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр хийх шаардлагатай байна.

Анхны баталгаажуулалтын үр дүн

Анхны баталгаажуулалтаар энэхүү шаардлагыг хангах чиглэлээр Монгол улс нь тодорхой хэмжээнд ахиц гаргасан хэмээн дүгнэжээ. ОТОБ нь ОУИТБС-ын хэрэгжилтэд гарч буй ахиц дэвшил, үр дүнгүүдийг баримтжуулсан жил тутмын тайланг бэлтгэн гаргаж буй ч үзүүлж буй нөлөөллийг шинжлэн судлах үйл ажиллагаа хийгдэхгүй буйг баталгаажуулалтын тайланд дурджээ. Түүнчлэн оролцогч гурван талын зөвхөн нэг нь л 2015 оны жилийн үйл ажиллагааны тайлан бэлтгэн гаргахад өөрийн саналыг өгч, оролцсон байна. Баталгаажуулалтаар санаачилгын үзүүлж буй нөлөөллийг үнэлэх чиглэлээр цаашид ажил хийгдэх шаардлагатай, жилийн тайланг боловсруулахад оролцогч талуудын оролцоог сайжруулан бэхжүүлэх шаардлагатай болохыг тогтоожээ.

Баталгаажуулалтаас хойш гарсан ахиц дэвшил

ОТОБ нь 2017 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн хурлаараа²⁸ 2017 оны ажлын тайлангийн төслийг хэлэлцэж, улмаар 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлаар²⁹ Үндэсний зөвлөл ажлын тайланг эцэслэн баталжээ. 2017 оны жилийн явцын тайлан, 2017 оны ажлын тайлангийн хэрэгжилтийн тайланг Монголын ОУИТБС-ын вебсайт дээр³⁰ болон ОУИТБС-ын вебсайтын Монгол улсын хамаарах хэсэг дээр³¹ 2018 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр байршуулсан байна. Гэвч ОУИТБС-ын Ажлын алба нь жилийн явцын тайлангийн анхны төслийг боловсруулан гаргаж, үүнтэй холбоотойгоор ОТОБ-ын бүх талуудад мэдээлэл хүргүүлэн, саналаа ирүүлэхийг хүсэмжилсэн болох нь нотлогдож буй

²⁸ Монголын ОУИТБС (2017 оны 11 сар), ‘ОТОБ-ын 45 дугаар хурлын тэмдэглэл, 2017 оны 11 дүгээр сарын 15’, Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс 2018 оны 1 дүгээр сард гарган өгсөн.

²⁹ Монголын ОУИТБС (2017 оны 12 сар), ‘Үндэсний зөвлөлийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл, 2017 оны 12 сарын 21’, Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс 2018 оны 1 дүгээр сард гарган өгсөн.

³⁰ Монголын ОУИТБС-ын ажлын төлөвлөгөө, тайлангуудыг үзнэ үү, 2018 оны 1 сарын байдлаар [энд](#) үзэх боломжтой.

³¹ ОУИТБС, Монголын ОУИТБС-ын жилийн явцын тайланг үзнэ үү, 2018 оны 1 сарын байдлаар [энд](#) үзэх боломжтой.

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээний төсөл

ч жилийн ажлын тайланд төрийн байгууллагуудын зүгээс л саналаа ирүүлсэн нь харагдаж байна.³² Баталгаажуулалтын үр дүнтэй холбоотой засан залруулах арга хэмжээний талаар 2017 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр болсон уулзалтаар ОТОБ нь 2017 оны жилийн ажлын тайлангийн төсөл дээр бүх оролцогч тал бичгээр санал өгнө хэмээн тохирчээ.³³ Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь ОТОБ-т хандан 2017 оны 11 дүгээр сарын 115-наас өмнө өөрийн саналыг ирүүлэх хүсэлт гарган цахим шуудангаар талуудтай харилцсан байна.³⁴ Монголын ОУИТБС-ын ажлын хэсэгтэй зөвлөлдсөний үндсэн дээр тухайн тайланд саналаа гарган өгөөгүй талуудын төлөөлөл нь (олборлох үйлдвэрлэлийн салбар болон иргэний нийгэм) жилийн тайлангийн төслийг боловсруулахад саналаа өгөөгүй талаар ямар нэгэн тайлбар өгөөгүйг тогтоосон.

2017 жилийн тайлан дээр 2016 онд хийгдсэн баталгаажуулалт болон 2015 оны ОУИТБС-ын тайланд дурдагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр гаргасан хүчин чармайлтыг тусгажээ (хуудас.14-15). Жилийн тайлан нь Монгол улс дахь ОУИТБС-ын хэрэгжилтэд буй сул талуудын үнэлгээний тойм, хэрэгжилтийг сайжруулах ерөнхий зөвлөмж зэргийг тусгажээ (хуудас.16). Тайланд мөн ОУИТБС-ын хэрэгжилтээс үүдэж буй нөлөөллийн төрлүүдийн тойм мэдээлэл (хуудас.4-5) тусгагдсан ч эдгээрийн ОУИТБС-тай онцгойлон холбогдох байдал нь тодорхойгүй хэвээр байна. ОТОБ нь 2015 оны ОУИТБС-ын тайлан болон 2016 оны баталгаажуулалтаас өгсөн зөвлөмжүүдийг 2017 онд зохион байгуулагдсан гурван хурлаараа хэлэлцсэн болох нь нотлогдож байна.³⁵ Хурлын тэмдэглэлүүдэд дурдсанчлан ОТОБ нь мөн 2017 онд өөрийн үйл ажиллагааны зарим үр дүн, нөлөөллийн талаар хэлэлцсэнээс хамгийн анзаарагдам нь 5 суманд хэрэгжиж буй орон нутгийн туршилтын төслийн үр дүнг иргэний нийгмийн төлөөллийн зүгээс үзүүлж буй нөлөөлөл хангалттай бус хэмээн үзсэнтэй холбоотой хэлэлцүүлэг байжээ.³⁶

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээ

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар нь жилийн явцын тайланд дурдсан засан залруулах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлжсэн хэмээн үзэж, Монгол улс нь 7.4 дүгээр шаардлагыг хангахад хангалттай хэмжээнд ахиц гаргасан хэмээн үзэж байна. 2017 оны жилийн ажлын тайланд өмнө хийгдсэн баталгаажуулалт, ОУИТБС-ын тайлангуудад тусгасан зөвлөмжүүдийн дагуу авч ОТОБ-ын зүгээс хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүнчлэн санаачилгын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээрх арга хэмжээний мэдээлэл, ОУИТБС-ын хэрэгжилтээс үүдэж буй үр нөлөөллийн талаарх ерөнхий ажиглалт зэргийг тоймлон тусгажээ. Жилийн ажлын тайлангийн төслийг бэлтгэн гаргахад ОТОБ-ын оролцогч талуудын оролцоо, хувь нэмрийг харуулах нотолгоо хангалтгүй буй нь санаа зовоохуйц асуудал хэдий ч Нарийн бичгийн дарга нарын газар нь тухайн оролцогч талуудад өөрийн хувь нэмрээ орлуулах хангалттай цаг, боломж олгогдсон хэмээн ойлгож байна. Шаардлага 7.4 нь “ОУИТБС-д хамаарах бүх оролцогч талууд ОУИТБС-ын жил тутмын үйл ажиллагааны тайланг бэлтгэхэд оролцох болон ОУИТБС-ын үзүүлж буй нөлөөллийг судлан үзэх боломжтой байх ёстой” (гол санааг тодруулсан) хэмээн заажээ. Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс ОУИТБС-ын хүрээнд гарч буй ахиц дэвшил болон нөлөөллийг судлан үзэх оролцогч талуудын боломжийг хаан хязгаарлах ямар нэгэн оролдлого гарч байгаагүй хэмээн үзэж байна. Харин ч оролцогч талууд нь өөрсдөө тухайн тайланд

³² Жишээ нь төрийн төлөөллийн ОУИТБС-тай холбоотой үйл ажиллагааг үзнэ үү, Хавсралт (хуудас.21) Монголын ОУИТБС (2018 оны 1 сар), ‘Монголын ОУИТБС-ын 2017 оны жилийн явцын тайлан’, 2018 оны 1 сарын байдлаар [энд](#) үзэх боломжтой.

³³ Монголын ОУИТБС (2017 оны 9 сар), ‘Баталгаажуулалтын засан залруулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тохирсон арга хэмжээ’, нийтлэгдээгүй, Монголын ОУИТБС-ын Ажлын албанаас гарган өгсөн.

³⁴ Монголын ОУИТБС (2017 оны 10 сар), 2017 оны жилийн тайлан дээр санал өгөхийг хүсэн ОТОБ-т илгээсэн цахим шуудан, хэвлэн нийтлэгдээгүй, Монголын ОУИТБС-ын Ажлын албанаас гарган өгсөн.

³⁵ Монголын ОУИТБС (2017), ОТОБ-ийн 43, 44 болон 45 дугаар хурлын тэмдэглэл, 2017 оны 2 сарын 23, 6 сарын 16, 11 сарын 25, 2018 оны 1 сарын байдлаар [энд](#) үзэх боломжтой.

³⁶ *Дээрхтэй ижил.*

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын үнэлгээний төсөл өгөх санал, оруулах хувь нэмэр үгүй хэмээн үзжээ. Нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс энэхүү үйл явцыг цаашид хэрхэн сайжруулах талаар ОТОБ дээр хэлэлцэхийг зөвлөмж болгож байна.

4. Дүгнэлт

ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооны зүгээс хүсэмжилсэн засан залруулах 8 үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн Монгол улсын алхамуудыг судлан үзсэний үндсэн дээр бүхий л засан залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж, хамаарах шаардлагуудыг ханган биелүүлэхэд Монгол улс нь “хангалттай хэмжээнд” ахиц гаргасан хэмээн үзэж байна.